Хэргийг цагаар нь авч үзвэл: 19-22 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 49 буюу 8.7 хувиар өсч, 14-19 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 37 буюу 3.5, 22-06 цагийн хооронд 11 буюу 1.0, хувиар буурч, 06 -14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

### 1.8. Гэмт хэрэг үйлдсэн газар




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг 6 буюу 1.7, гудамж талбайд 38 буюу 4.9, аж ахуйн нэгж, байгууллагад 16 буюу 5.8, төрийн байгууллагад 6 буюу 23.1, төрийн бус байгууллагад 8 буюу 47.1, бусад газарт 117 буюу 54.4 хувиар өсч, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 95 буюу 5.3, нийтийн тээвэрт 24 буюу 39.3, авто замд 71 буюу 40.6 хувиар тус тус буурсан байна.

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Сонгинохайрхан дүүрэгт 38.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 8.1 нэгжээр өссөн.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 9.3 нэгжээр их байна.

### 2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 3566 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 375 хэрэг буюу 11.8 хувиар, үүнээс 1360 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 402 буюу 42.0 хувиар өссөн тус тус байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 1635 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 хувиар буурсан.

Холбогдогчдын 223 буюу 13.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 5.2 хувиар өсч, 1412 буюу 86.4 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 4.4 хувиар, 104 буюу 6.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 10.3 хувиар тус тус буурсан байна.

### 3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 3617 хүн, 6 хуулийн этгээд хохирч, үүнээс 117 хүн нас барж, 978 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 11 буюу 10.4 хувиар өсч, гэмтсэн хүн 189 буюу 16.2 хувиар буурсан байна.

### 4.2. Учирсан хохирол

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 7506.8 сая төгрөгийн хохирлын 30.3 хувийг нөхөн төлүүлж, 151.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.




## Тав. Зөрчил

Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн хэмжээнд нийт 12447 зөрчил шалгаж, 12134 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14884 буюу 55.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 7945 буюу 63.8 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 285 буюу 2.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 4217 буюу 33.9 хувь нь бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 11951 иргэн, 9 хуулийн этгээдийг 359.0 сая төгрөгөөр торгох, 174 хүнийг баривчлах шийтгэл тус тус ногдуулжээ.

Сонгинохайрхан дүүрэгт нийт 8046 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 879 буюу 12.3 хувиар өссөн байна.

# ХАН-УУЛ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

### 1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд 2018 онд иргэн, хуулийн этгээдээс 7934 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 4467 буюу 56.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3467 буюу 43.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

### 1.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 2332 гэмт хэрэг бүртгэгдсэн өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 432 буюу 22.7 хувиар өсч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 9.1 хувийг эзэлж байна.

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/**




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 1449 гэмт хэрэг, сард 121 гэмт хэрэг, хоногт 4 гэмт хэрэг бүртгэгдсэн.

### 1.3. Бүртгэгдсэн гэмт хэрэг /хороодоор/



| № | Хороо | 2017 | 2018 | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| 1 | 1-р хороо | 104 | 116 | 12 | 11.5 |
| 2 | 2-р хороо | 199 | 229 | 30 | 15.1 |
| 3 | 3-р хороо | 206 | 311 | 105 | 51.0 |
| 4 | 4-р хороо | 154 | 205 | 51 | 33.1 |
| 5 | 5-р хороо | 45 | 62 | 17 | 37.8 |
| 6 | 6-р хороо | 52 | 54 | 2 | 3.8 |
| 7 | 7-р хороо | 42 | 36 | -6 | -14.3 |
| 8 | 8-р хороо | 80 | 89 | 9 | 11.3 |
| 9 | 9-р хороо | 62 | 78 | 16 | 25.8 |
| 10 | 10-р хороо | 169 | 198 | 29 | 17.2 |
| 11 | 11-р хороо | 239 | 300 | 61 | 25.5 |
| 12 | 12-р хороо | 65 | 72 | 7 | 10.8 |
| 13 | 13-р хороо | 49 | 48 | -1 | -2.0 |
| 14 | 14-р хороо | 65 | 88 | 23 | 35.4 |
| 15 | 15-р хороо | 276 | 344 | 68 | 24.6 |
| 16 | 16-р хороо | 93 | 102 | 9 | 9.7 |




### 1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад:
- хөнгөн гэмт хэрэг 54.7 хувиар,
- хүнд гэмт хэрэг 14.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### 1.5. Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, нийслэлийн хэмжээний нийт гэмт хэрэгт эзлэх хувь[7]




### 1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /*Эрүүгийн хуулийн бүлгээр*/

| № | Гэмт хэргийн төрөл | Бүртгэгдсэн хэрэг | | Өсөлт, бууралтын хувь | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | 2017 он | 2018 он | | |
| 1 | Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг | 48 | 46 | -4.2 | 2.0 |
| | Үүнээс: Хүнийг алах | 7 | 6 | -14.3 | 0.3 |
| 2 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 533 | 616 | 15.6 | 26.4 |
| | Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх | 26 | 18 | -30.8 | 0.8 |

[7] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 28 | 21 | -25.0 | 0.9 |
| | Үүнээс: Хүчиндэх | 19 | 17 | -10.5 | 0.7 |
| 4 | Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг | 6 | 7 | 16.7 | 0.3 |
| 5 | Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг | 2 | 1 | -50.0 | 0.04 |
| 6 | Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг | 2 | 1 | -50.0 | 0.04 |
| 7 | Хүүхдийн эсрэг гэмт хэрэг | - | 1 | - | 0.04 |
| 8 | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | 1025 | 1441 | 40.6 | 61.8 |
| | Үүнээс: Хулгайлах | 636 | 713 | 12.1 | 30.6 |
| | Залилах | 196 | 442 | 2.3 дахин | 19.0 |
| | Дээрэмдэх | 51 | 62 | 21.6 | 2.7 |
| | Мал хулгайлах | 9 | 17 | 88.9 | 0.7 |
| 9 | Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг | 29 | 24 | -17.2 | 1.0 |
| 10 | Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 7 | 11 | 57.1 | 0.5 |
| 11 | Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | 77 | 26 | -66.2 | 1.1 |
| 12 | Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг | 8 | 18 | 2.3 дахин | 0.8 |
| 13 | Авлигын эсрэг гэмт хэрэг | 10 | 23 | 2.3 дахин | 1.0 |
| 14 | Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | 22 | 10 | -54.5 | 0.4 |
| 15 | Хүрээлэн байгаа орчны эсрэг | 6 | 1 | -83.3 | 0.04 |
| 16 | Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 9 | 6 | -33.3 | 0.3 |
| 17 | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 88 | 79 | -10.2 | 3.4 |
| | Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих | 70 | 79 | 12.9 | 3.4 |

### 1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 114 буюу 43.3, Мягмар гарагт 65 буюу 23.6, Лхагва гарагт 49 буюу 18.4, Пүрэв гарагт 64 буюу 22.5, Баасан гарагт 30 буюу 9.0, Бямба гарагт 62 буюу 26.1, Ням гарагт 48 буюу 20.1 хувиар тус тус өсчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 139 буюу 28.6, 14-19 цагийн хооронд 209 буюу 40.0, 19-22 цагийн хооронд 33 буюу 10.8 хувиар, 22-06 цагийн хооронд 51 буюу 8.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### 1.8. Гэмт хэрэг үйлдсэн газар




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 114 буюу 16.4, аж ахуйн нэгж, байгууллагад 63 буюу 28.5, гудамж талбайд 102 буюу 32.9, төрийн бус байгууллагад 6 буюу 42.9, төрийн байгууллагад 20 буюу 47.6, нийтийн тээвэрт 22 буюу 71.0, бусад газарт 163 буюу 71.8 хувиар тус тус өсч, авто замд үйлдэгдсэн хэрэг 7 буюу 7.9, олон нийтийн газарт 51 буюу 18.8 хувиар тус тус буурсан байна.

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Хан-Уул дүүрэгт 31.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.5 нэгжээр өссөн.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 2.9 нэгжээр их байна.

### 2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн

Хэрэг бүртгэлтийн 2262 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 847 хэрэг буюу 59.9 хувиар, үүнээс 718 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 304 буюу 73.4 хувиар тус тус өсчээ.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 849 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.6 хувиар буурсан. Холбогдогчдын 114 буюу 13.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 16.8 хувиар, 735 буюу 86.6 хувь нь эрэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 14.2 хувиар, 45 буюу 5.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.1 хувиар тус тус буурсан байна.

### 3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 1730 хүн, 1 хуулийн этгээд хохирч, үүнээс 39 хүн нас барж, 427 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 6 буюу 13.3 хувиар, гэмтсэн хүн 68 буюу 13.7 хувиар тус тус буурсан байна.

### 4.2. Учирсан хохирол

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 9390.6 сая төгрөгийн хохирлын 29.4 хувийг нөхөн төлүүлж, 914.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.




## Тав. Зөрчил

Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн хэмжээнд нийт 8392 зөрчил шалгаж, 8023 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4252 буюу 34.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 5 буюу 0.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 3561 буюу 42.4 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 462 буюу 5.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 4364 буюу 52.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 7556 иргэн, 1 хуулийн этгээдийг 364.9 сая төгрөгөөр торгох, 466 хүнийг баривчлах шийтгэл тус тус ногдуулжээ.

Хан-Уул дүүрэгт нийт 5609 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 552 буюу 10.9 хувиар өссөн байна.

---oooOooo--

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

### 1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд 2018 онд иргэн, хуулийн этгээдээс 15905 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 4858 буюу 30.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 11047 буюу 69.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

### 1.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 2776 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 57 хэргээр буюу 2.1 хувиар өсч, нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 10.8 хувийг эзэлж байна.

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/**




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 2073 гэмт хэрэг, сард 173 гэмт хэрэг, хоногт 6 гэмт хэрэг бүртгэгдсэн.

### 1.3. Бүртгэгдсэн гэмт хэрэг /хороодоор/:



| № | Хороо | 2017 | 2018 | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| 1 | 1-р хороо | 214 | 249 | 35 | 16.4 |
| 2 | 2-р хороо | 218 | 205 | -13 | -6.0 |
| 3 | 3-р хороо | 263 | 278 | 15 | 5.7 |
| 4 | 4-р хороо | 166 | 241 | 75 | 45.2 |
| 5 | 5-р хороо | 210 | 236 | 26 | 12.4 |
| 6 | 6-р хороо | 95 | 136 | 41 | 43.2 |
| 7 | 7-р хороо | 115 | 134 | 19 | 16.5 |
| 8 | 8-р хороо | 70 | 66 | -4 | -5.7 |
| 9 | 9-р хороо | 90 | 84 | -6 | -6.7 |
| 10 | 10-р хороо | 98 | 105 | 7 | 7.1 |
| 11 | 11-р хороо | 135 | 112 | -23 | -17.0 |
| 12 | 12-р хороо | 188 | 199 | 11 | 5.9 |
| 13 | 13-р хороо | 114 | 99 | -15 | -13.2 |
| 14 | 14-р хороо | 96 | 78 | -18 | -18.8 |
| 15 | 15-р хороо | 74 | 58 | -16 | -21.6 |
| 16 | 16-р хоро | 103 | 85 | -18 | -17.5 |
| 17 | 17-р хороо | 110 | 84 | -26 | -23.6 |
| 18 | 18-р хороо | 107 | 90 | -17 | -15.9 |
| 19 | 19-р хороо | 253 | 237 | -16 | -6.3 |




### 1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад:
- хөнгөн гэмт хэрэг 35.9 хувиар,
- хүнд гэмт хэрэг 12.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### 1.5. Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, нийслэлийн хэмжээний нийт гэмт хэрэгт эзлэх хувь[8]




### 1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /*Эрүүгийн хуулийн бүлгээр*/:

| № | Гэмт хэргийн төрөл | Бүртгэгдсэн хэрэг | | Өсөлт, бууралтын хувь | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | 2017 он | 2018 он | | |
| 1 | Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг | 42 | 38 | -9.5 | 1.4 |

[8] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Үүнээс: Хүнийг алах | 17 | 19 | 11.8 | 0.7 |
| 2 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 585 | 601 | 2.7 | 21.6 |
| | Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх | 19 | 5 | -73.7 | 0.2 |
| 3 | Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 34 | 27 | -20.6 | 1.0 |
| | Үүнээс: Хүчиндэх | 24 | 21 | -12.5 | 0.8 |
| 4 | Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг | 8 | 10 | 25.0 | 0.4 |
| 5 | Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг | 1 | - | - | - |
| 6 | Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг | 1 | 2 | 100.0 | 0.1 |
| 7 | Хүүхдийн эсрэг | 1 | - | - | - |
| 8 | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | 1819 | 1926 | 5.9 | 69.4 |
| | Үүнээс: Хулгайлах | 1167 | 1013 | -13.2 | 36.5 |
| | Залилан | 377 | 616 | 63.4 | 22.2 |
| | Дээрэмдэх | 110 | 87 | -20.9 | 3.1 |
| 9 | Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг | 15 | 21 | 40.0 | 0.8 |
| 10 | Үндэсний аюулгүй байдлыг эсрэг | 2 | - | - | - |
| 11 | Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | 87 | 29 | -66.7 | 1.0 |
| 12 | Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг | 10 | 15 | 50.0 | 0.5 |
| 13 | Авлигын эсрэг гэмт хэрэг | 15 | 27 | 80.0 | 1.0 |
| 14 | Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | 30 | 16 | -46.7 | 0.6 |
| 15 | Хүрээлэн байгаа орчны эсрэг | 1 | 5 | 5.0 дахин | 0.2 |
| 16 | Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 6 | 6 | 0.0 | 0.2 |
| 17 | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 62 | 51 | -17.7 | 1.8 |
| | Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих | 48 | 51 | 6.3 | 1.8 |
| 18 | Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг | - | 1 | - | 0.04 |
| 19 | Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг | -- | 1 | - | 0.04 |

### 1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 14 буюу 3.2, Мягмар гарагт 57 буюу 14.8, Лхагва гарагт 15 буюу 3.6, Баасан гарагт 47 буюу 11.7 хувиар тус тус өсч, Пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 3 буюу 0.8, Бямба гарагт 45 буюу 12.7, Ням гарагт 28 буюу 8.3 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 57 буюу 7.1, 14-19 цагийн хооронд 15 буюу 1.7, 22-06 цагийн хооронд 13 буюу 2.0 хувиар өсч, 19-22 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 28 буюу 7.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

### 1.8. Гэмт хэрэг үйлдсэн газар




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 17 буюу 2.7, бусад газарт 25 буюу 13.6, нийтийн тээвэрт 4 буюу 22.2, төрийн бус байгууллагад 8 буюу 42.1, аж ахуйн нэгжид 113 буюу 45.4, төрийн байгууллагад 30 буюу 63.8 хувиар тус тус өсч, авто замд үйлдэгдсэн хэрэг 2 буюу 3.2, олон нийтийн газарт 33 буюу 7.3, гэр орон сууцанд 105 буюу 9.9 хувиар тус тус буурсан байна.

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Чингэлтэй дүүрэгт 34.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.6 нэгжээр буурсан.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 5.3 нэгжээр их байна

### 2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 2721 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 456 хэрэг буюу 20.1 хувиар, үүнээс 929 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 143 буюу 18.2 хувиар өссөн тус тус байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 1137 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.5 хувиар буурсан.

Холбогдогчдын 166 буюу 14.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 41.5 хувиар, 971 буюу 85.4 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 15.3 хувиар, 90 буюу 7.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 11.8 хувиар тус тус буурчээ.

### 3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 2633 хүн, 1 хуулийн этгээд хохирч, үүнээс 38 хүн нас барж, 634 хүн гэмтсэн нь нас барсан хүн өмнөх оны мөн үеийнхээс 2 буюу 5.0 буурч, гэмтсэн хүн 13 буюу 2.1 хувиар өссөн байна.

### 4.2. Учирсан хохирол

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 20067.2 сая төгрөгийн хохирлын 13.2 хувийг нөхөн төлүүлж, 469.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.




## Тав. Зөрчил

Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн хэмжээнд нийт 8569 зөрчил шалгаж, 7698 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11081 буюу 59.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 1743 буюу 20.3 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 3223 буюу 37.6 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 285 буюу 3.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 3318 буюу 38.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 7540 иргэн, 14 хуулийн этгээдийг 329.6 сая төгрөгөөр торгох, 144 хүнийг баривчлах шийтгэл тус тус ногдуулсан.

# БАГАНУУР ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

### 1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Баганаар дүүрэг дэх цагдаагийн хэлтэст 2018 онд иргэн, хуулийн этгээдээс 2468 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 482 буюу 19.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1986 буюу 80.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

### 1.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 253 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1 хэргээр буюу 0.4 хувиар буурч, нийслэлд үйлдэгдсэн гэмт хэргийн 1.0 хувийг эзэлж байна.

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/**




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 267 гэмт хэрэг, сард 22 гэмт хэрэг, хоногт 1 гэмт хэрэг бүртгэгдсэн.

### 1.3. Бүртгэгдсэн гэмт хэрэг /хороодоор/




| № | Сум | 2017 | 2018 | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| 1 | 1-р хороо | 83 | 82 | -1 | -1.2 |
| 2 | 2-р хороо | 25 | 17 | -8 | -32.0 |
| 3 | 3-р хороо | 51 | 62 | 11 | 21.6 |
| 4 | 4-р хороо | 34 | 37 | 3 | 8.8 |
| 5 | 5-р хороо | 61 | 55 | -6 | -9.8 |

### 1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад:
- хөнгөн гэмт хэрэг 11.4 хувиар,
- хүнд гэмт хэрэг 26.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### 1.5. Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, нийслэлийн хэмжээний нийт гэмт хэрэгт эзлэх хувь[9]

### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /*Эрүүгийн хуулийн бүлгээр*/

| № | Гэмт хэргийн төрөл | | Бүртгэгдсэн хэрэг | | Өсөлт, бууралтын хувь | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2017 он | 2018 он | | |
| 1 | Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг | | 4 | 6 | 50.0 | 2.4 |
| | Үүнээс: Хүнийг алах | | 1 | 1 | 0.0 | 0.4 |
| 2 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | | 106 | 101 | -4.7 | 39.9 |
| | Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх | | 3 | 3 | 0.0 | 1.2 |
| 3 | Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | | 8 | 12 | 50.0 | 4.7 |
| | Үүнээс: Хүчиндэх | | 5 | 8 | 60.0 | 3.2 |
| 4 | Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг | | - | 1 | - | 0.4 |
| 5 | Хүүхдийн эсрэг гэмт хэрэг | | - | 1 | - | 0.4 |
| 6 | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | | 112 | 104 | -7.1 | 41.1 |
| | Үүнээс | Хулгайлах | 66 | 63 | -4.5 | 24.9 |
| | | Залилах | 17 | 12 | -29.4 | 4.7 |
| | | Дээрэмдэх | 3 | | | |
| | | Мал хулгайлах | 8 | 10 | 25.0 | 4.0 |

[9] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг | - | 1 | - | 0.4 |
| 8 | Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | 9 | 5 | -44.4 | 1.9 |
| 9 | Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг | - | 1 | - | 0.4 |
| 10 | Авлигын эсрэг гэмт хэрэг | 1 | 3 | 3.0 дахин | 1.2 |
| 11 | Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | 2 | 8 | 4.0 дахин | 3.2 |
| 12 | Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг | 1 | - | - | - |
| 13 | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 11 | 10 | -9.1 | 4.0 |
| | Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих | 8 | 10 | 25.0 | 4.0 |

### 1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 13 буюу 43.3, Ням гарагт 8 буюу 22.2 хувиар тус тус өсч, Мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 6 буюу 17.1, Лхагва гарагт 10 буюу 27.0, Баасан гарагт 1 буюу 2.7, Бямба гарагт 5 буюу 11.6 хувиар тус тус буурч, Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг мөн үеийн түвшинд.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06 -14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 4 буюу 7.7, 19-22 цагийн хооронд 8 буюу -20.0 хувиар өсч, 14-19 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 3 буюу 4.2, 22-06 цагийн хооронд 10 буюу 11.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### 1.8. Гэмт хэрэг үйлдсэн газар




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Бусад газарт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 2.5 хувиар, төрийн бус байгууллагад 1 буюу 2.0 дахин, төрийн байгууллагад үйлдэгдсэн хэрэг 6 буюу 3.0 дахин, аж ахуйн нэгж, байгууллагад 10 буюу 2.4 дахин тус тус өсч, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 3 буюу 2.6, авто замд 1 буюу 9.1, олон нийтийн газарт 3 буюу 10.3, гудамж талбайд 12 буюу 25.5 хувиар тус тус буурсан байна.

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Багануур дүүрэгт 57.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 8.3 нэгжээр өссөн байна.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 28.9 нэгжээр их байна.

### 2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 213 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 45 хэрэг буюу 26.8 хувиар, үүнээс 123 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 40 буюу 48.2 хувиар тус тус өссөн байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 178 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.9 хувиар буурсан. Холбогдогчдын 21 буюу 11.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 36.4 хувиар, 157 буюу 88.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 7.1 хувиар, 13 буюу 7.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.6 хувиар тус тус буурсан байна.

### 3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1. Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 262 хүн хохирч, үүнээс 6 хүн нас барж, 111 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 1 буюу 14.3 хувиар, гэмтсэн хүн 21 буюу 15.9 хувиар тус тус буурсан байна.

### 4.2. Учирсан хохирол

Иргэнд учирсан 319.7 сая төгрөгийн хохирлын 21.9 хувийг нөхөн төлүүлсэн байна.



**Тав. Зөрчил**

Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн хэмжээнд нийт 24369 зөрчил шалгаж, 24259 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7216 буюу 42.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 23695 буюу 97.2 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 25 буюу 0.1 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 71 буюу 0.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 578 буюу 2.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 23835 иргэн, 1 хуулийн этгээдийг 770.7 сая төгрөгөөр торгох, 150 хүнийг баривчлах, 273 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулжээ.

Багануур дүүрэгт нийт 1327 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 835 буюу 38.6 хувиар буурсан байна.

---oooOooo---

# БАГАХАНГАЙ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

### 1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Багахангай дүүргийн цагдаагийн хэлтэст 2018 онд иргэн, хуулийн этгээдээс 197 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 89 буюу 45.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 108 буюу 54.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

### 1.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 24 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7 хэргээр буюу 22.6 хувиар буурч, нийслэл бүртгэгдсэн гэмт хэргийн 0.1 хувийг эзэлж байна.

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/**




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 22 гэмт хэрэг, сард 2 гэмт хэрэг бүртгэгдсэн.

### 1.3. Бүртгэгдсэн гэмт хэрэг /хороодоор/:




| № | Хороо | 2017 | 2018 | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| | 1-р хороо | 18 | 15 | -3 | -16.6 |
| | 2-р хороо | 13 | 9 | -4 | -30.8 |




### 1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад:
- хөнгөн гэмт хэрэг 5.3 хувиар буурч,
-хүнд гэмт хэрэг 50.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### 1.5. Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, нийслэлийн хэмжээний нийт гэмт хэрэгт эзлэх хувь[10]




### 1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /*Эрүүгийн хуулийн бүлгээр*/:

| № | Гэмт хэргийн төрөл | Бүртгэгдсэн хэрэг | | Өсөлт, бууралтын хувь | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | 2017 он | 2018 он | | |
| 1 | Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг | 1 | | | |
| 2 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 13 | 10 | -23.1 | 41.7 |
| | Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх | 1 | 2 | 2.0 дахин | 8.3 |
| 3 | Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 1 | - | - | - |
| 4 | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | 11 | 9 | -18.2 | 37.5 |
| | Хулгайлах | 3 | 6 | 2.0 дахин | 25.0 |
| | Залилан | 3 | 1 | 66.7 | 4.2 |
| | Мал хулгайлах | 3 | 1 | 66.7 | 4.2 |
| 5 | Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | 1 | - | - | - |
| 6 | Хүрээлэн байгаа орчины эсрэг гэмт хэрэг | 1 | - | - | - |
| 7 | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 3 | 5 | 66.7 | 20.8 |
| | Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих | 3 | 5 | 66.7 | 20.8 |

### 1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 5 буюу 6.0 дахин, Пүрэв гарагт 2 буюу 66.7, Ням гарагт 1 буюу 33.3 хувиар тус тус өсч, Мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 2 буюу 50.0, Лхагва гарагт 2 буюу 40.0, Баасан гарагт 4 буюу 66.7, Бямба гарагт 7 буюу 77.8 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 3 буюу 37.5 хувиар өсч, 14-19 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 10 буюу 0.2 хувиар буурч, 06-14, 19-22 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг өмнөх оны мөн үеийн түвшинд үзүүлэлттэй байна.

[10] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

### 1.8. Гэмт хэрэг үйлдсэн газар




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Авто замд үйлдэгдсэн хэрэг 1 буюу 33.3 хувиар өсч, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хэрэг 1 буюу 33.3, бусад газарт 3 буюу 50.0, гудамж талбайд 3 буюу 75.0 хувиар тус тус буурч, гэр, орон сууц, олон нийтийн газар, төрийн бус байгууллагад үйлдэгдсэн хэрэг тус тус өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Багахангай дүүрэгт 45.8 хувьтай байгаа нь 16.4 нэгжээр өссөн.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 17.0 нэгжээр их байна.

### 2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 24 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7 хэрэг буюу 41.2 хувиар, үүнээс 11 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6 буюу 2.2 дахин өсчээ.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 14 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.4 хувиар буурсан.

Холбогдогчдын 1 буюу 7.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 75.0 хувиар, 13 буюу 92.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 27.8 хувиар буурч, 1 буюу 7.1 хувийг хүүхэд эзэлж байна.

### 3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал






## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1. Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 21 хүн хохирч, үүнээс 1 хүн нас барж, 9 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүн 7 буюу 43.7 хувиар буурсан байна.

### 4.2. Учирсан хохирол

Иргэнд учирсан 39.7 сая төгрөгийн хохирлын 84.0 хувийг нөхөн төлүүлжээ.




## Тав. Зөрчил

Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн хэмжээнд нийт 13176 зөрчил шалгаж, 13171 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3056 буюу 30.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 13040 буюу 98.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 10 буюу 0.1 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 126 буюу 1.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 13144 иргэнийг 373.5 сая төгрөгөөр торгох, 3 хүнийг баривчлах, 24 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулжээ.

Багахангай дүүрэгт нийт 164 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 38 буюу 18.9 хувиар буурсан байна.

---oooOooo---

# НАЛАЙХ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

### 1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс 2018 онд иргэн, хуулийн этгээдээс 4125 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 754 буюу 18.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3371 буюу 81.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

### 1.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 420 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 27 хэргээр буюу 6.9 хувиар буурч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.6 хувийг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 347 гэмт хэрэг, сард 29 гэмт хэрэг, хоногт 1 гэмт хэрэг бүртгэгдсэн.

### 1.3. Бүртгэгдсэн гэмт хэрэг /хороодоор/



| № | Сум | 2017 | 2018 | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| 1 | 1-р хороо | 91 | 105 | 14 | 15.4 |
| 2 | 2-р хороо | 99 | 89 | -10 | -10.1 |
| 3 | 3-р хороо | 68 | 66 | -2 | -2.9 |
| 4 | 4-р хороо | 26 | 32 | 6 | 23.1 |
| 5 | 5-р хороо | 24 | 39 | 15 | 62.5 |
| 6 | 6-р хороо | 45 | 47 | 2 | 4.4 |
| 7 | 7-р хороо | 40 | 42 | 2 | 5.0 |

### 1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад:
-хөнгөн гэмт хэрэг 28.8 хувиар,
-хүнд гэмт хэрэг 46.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### 1.5. Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, нийслэлийн хэмжээний нийт гэмт хэрэгт эзлэх хувь[11]




### 1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /*Эрүүгийн хуулийн бүлгээр*/

| № | Гэмт хэргийн төрөл | Бүртгэгдсэн хэрэг | | Өсөлт, бууралтын хувь | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | 2017 он | 2018 он | | |
| 1 | Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг | 16 | 15 | -6.3 | 3.6 |
| | Үүнээс: Хүнийг алах | 6 | 4 | -33.3 | 1.0 |
| 2 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 154 | 161 | 4.5 | 38.3 |
| | Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх | 8 | 3 | -62.5 | 0.7 |

[11] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | | 7 | 5 | -28.6 | 1.2 |
| | Үүнээс: Хүчиндэх | | 5 | 4 | -20.0 | 1.0 |
| 4 | Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг | | 1 | - | - | - |
| 5 | Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг | | 7 | - | - | - |
| 6 | Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг | | - | 1 | - | 0.2 |
| 7 | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | | 159 | 193 | 21.4 | 46.0 |
| | Үүнээс | Хулгайлах | 117 | 135 | 15.4 | 32.1 |
| | | Залилах | 21 | 25 | 19.0 | 6.0 |
| | | Дээрэмдэх | 3 | 7 | 2.3 дахин | 1.7 |
| | | Мал хулгайлах | 10 | 10 | | 2.4 |
| 8 | Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | | 23 | - | - | - |
| 9 | Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг | | - | 6 | - | 1.4 |
| 10 | Авлигын эсрэг гэмт хэрэг | | 1 | 9 | 9.0 дахин | 2.1 |
| 11 | Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | | 3 | 2 | -33.3 | 0.5 |
| 12 | Хүрээлэн байгаа орчны эсрэг | | 4 | 1 | -75.0 | 0.2 |
| 13 | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | | 18 | 22 | 22.2 | 5.3 |
| | Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих | | 18 | 21 | 16.7 | 5.0 |
| 14 | Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг | | - | 5 | - | 1.2 |

### 1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 3 буюу 5.2, Пүрэв 19 буюу 37.3, Баасан 4 буюу 7.5, Бямба 15 буюу 35.7, Ням 15 буюу 31.9 хувиар тус тус өсч, Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 17 буюу 22.4, Мягмар гарагт 12 буюу 18.2 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06 - 14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 7 буюу 9.1, 22-06 цагийн хооронд 55 буюу 49.5 хувиар тус тус өсч, 14-19 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 26 буюу 30.6, 19-22 цагийн хооронд 9 буюу 7.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### 1.8. Гэмт хэрэг үйлдсэн газар




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Авто замд үйлдэгдсэн хэрэг 1 буюу 5.0, аж ахуйн нэгж байгууллагад 7 буюу 31.8, гудамж талбайд 19 буюу 37.3 хувиар, төрийн байгууллагад 15 буюу 3.1 дахин тус тус өсч, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 5 буюу 3.2, олон нийтийн газарт 4 буюу 6.7, бусад газарт 6 буюу 7.8 хувиар тус тус буурч, нийтийн тээвэр, төрийн бус байгууллагад үйлдэгдсэн хэрэг өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Налайх дүүрэгт 42.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.4 нэгжээр өссөн.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 13.6 нэгжээр их байна.

### 2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн

Хэрэг бүртгэлтийн 394 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 122 хэрэг буюу 44.9 хувиар, үүнээс 167 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 61 буюу 57.5 хувиар тус тус өсчээ.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 244 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.0 хувиар буурсан. Холбогдогчдын 24 буюу 9.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 33.3 хувиар буурч, 220 буюу 90.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.3 хувь, 11 буюу 4.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 83.3 хувиар тус тус өссөн байна.

### 3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал







**Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол**

### 4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 407 хүн, 1 хуулийн этгээд хохирч үүнээс 25 хүн нас барж, 180 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 8 буюу 47.1 хувиар өсч, гэмтсэн хүн 12 буюу 6.3 хувиар буурсан байна.

### 4.2. Учирсан хохирол

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 824.5 сая төгрөгийн хохирлын 55.5 хувийг нөхөн төлүүлж 10.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

**Тав. Зөрчил**

Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн хэмжээнд нийт 19949 зөрчил шалгаж, 19849 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5496 буюу 38.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 19298 буюу 96.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 104 буюу 0.5 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 18 буюу 0.1 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 529 буюу 2.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 19329 иргэн, 1 хуулийн этгээдийг 826.9 сая төгрөгөөр торгох, 50 хүнийг баривчлах, 469 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулжээ.

Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэст нийт 3343 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 523 буюу 18.5 хувиар өссөн байна.

---oooOooo---

# ГУРАВ. ОРОН НУТАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

### 1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Орон нутгийн цагдаагийн байгууллагуудад 2018 онд иргэн, хуулийн этгээдээс 61273 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 17320 буюу 28.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 43953 буюу 71.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

### 1.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 10504 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 231 хэргээр буюу 2.2 хувиар өсч, улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 29.0 хувийг эзэлж байна.

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/**




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 9432 гэмт хэрэг, сард 786 гэмт хэрэг, хоногт 26 гэмт хэрэг бүртгэгдсэн.

### 1.3. Бүртгэгдсэн гэмт хэрэг /аймгаар/

| № | Газар хэлтэс | 2017 | 2018 | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| 1 | Архангай | 514 | 519 | 5 | 1.0 |
| 2 | Баян-Өлгий | 319 | 318 | -1 | -0.3 |
| 3 | Баянхонгор | 563 | 581 | 18 | 3.2 |
| 4 | Булган | 362 | 344 | -18 | -5.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Говь-Алтай | 200 | 203 | 3 | 1.5 |
| 6 | Говьсүмбэр | 171 | 176 | 5 | 2.9 |
| 7 | Дархан-Уул | 768 | 818 | 50 | 6.5 |
| 8 | Дорноговь | 654 | 517 | -137 | -20.9 |
| 9 | Дорнод | 582 | 602 | 20 | 3.4 |
| 10 | Дундговь | 216 | 266 | 50 | 23.1 |
| 11 | Завхан | 221 | 235 | 14 | 6.3 |
| 12 | Орхон | 881 | 794 | -87 | -9.9 |
| 13 | Өвөрхангай | 492 | 670 | 178 | 36.2 |
| 14 | Өмнөговь | 462 | 429 | -33 | -7.1 |
| 15 | Сүхбаатар | 338 | 366 | 28 | 8.3 |
| 16 | Сэлэнгэ | 729 | 779 | 50 | 6.9 |
| 17 | Төв | 810 | 779 | -31 | -3.8 |
| 18 | Увс | 356 | 332 | -24 | -6.7 |
| 19 | Ховд | 433 | 363 | -70 | -16.2 |
| 20 | Хөвсгөл | 749 | 787 | 38 | 5.1 |
| 21 | Хэнтий | 453 | 626 | 173 | 38.2 |




### 1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад:
-хөнгөн гэмт хэрэг 19.8 хувиар,
-хүнд гэмт хэрэг 54.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### 1.5. Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, улсын хэмжээний нийт гэмт хэрэгт эзлэх хувь[12]




[12] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

### 1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /*Эрүүгийн хуулийн бүлгээр*/

| № | Гэмт хэргийн төрөл | | Бүртгэгдсэн хэрэг | | Өсөлт, бууралтын хувь | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2017 он | 2018 он | | |
| 1 | Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг | | 243 | 281 | 15.6 | 2.7 |
| | Үүнээс: Хүнийг алах | | 71 | 82 | 15.5 | 0.8 |
| 2 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | | 3406 | 3254 | -4.5 | 31.0 |
| | Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх | | 71 | 105 | 47.9 | 1.0 |
| 3 | Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | | 276 | 305 | 10.5 | 2.9 |
| | Үүнээс: Хүчиндэх | | 182 | 249 | 36.8 | 2.4 |
| 4 | Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг | | 14 | 22 | 57.1 | 0.2 |
| 5 | Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг | | 9 | - | - | - |
| 6 | Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг | | 10 | 10 | 0.0 | 0.1 |
| 7 | Хүүхдийн эсрэг гэмт хэрэг | | 4 | 2 | -50.0 | 0.0 |
| 8 | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | | 4545 | 4987 | 9.7 | 47.5 |
| | Үүнээс | Хулгайлах | 2729 | 2789 | 2.2 | 26.6 |
| | | Залилах | 330 | 623 | 88.8 | 5.9 |
| | | Дээрэмдэх | 152 | 137 | -9.9 | 1.3 |
| | | Мал хулгайлах | 820 | 1003 | 22.3 | 9.5 |
| 9 | Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг | | 95 | 68 | -28.4 | 0.6 |
| 10 | Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг | | 24 | 58 | 2.4 дахин | 0.6 |
| 11 | Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | | 291 | 88 | -69.8 | 0.8 |
| 12 | Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг | | 41 | 67 | 63.4 | 0.6 |
| 13 | Авлигын эсрэг гэмт хэрэг | | 52 | 192 | 3.7 дахин | 1.8 |
| 14 | Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | | 96 | 99 | 3.1 | 1.0 |
| 15 | Хүрээлэн байгаа орчны эсрэг | | 289 | 346 | 19.7 | 3.3 |
| 16 | Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг | | - | 2 | - | 0.02 |
| 17 | Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг | | 1 | 2 | 2.0 дахин | 0.02 |
| 18 | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | | 872 | 714 | -18.1 | 6.8 |
| | Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих | | 782 | 704 | -10.0 | 6.7 |
| 19 | Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг | | 5 | 7 | 40.0 | 0.1 |

### 1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 139 буюу 9.1, Мягмар гарагт 26 буюу 1.7, Баасан гарагт 72 буюу 4.8, Бямба гарагт 79 буюу 5.9 хувиар тус тус өсч, Лхагва гарагт 17 буюу 1.1, Пүрэв гарагт 17 буюу 1.2, Ням гарагт 51 буюу 3.7 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06 -14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 259 буюу 13.0, 14-19 цагийн хооронд 147 буюу 5.4 хувиар тус тус өсч, 19-22 цагийн хооронд 45 буюу 2.6, 22-06 цагийн хооронд 130 буюу 3.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### 1.8. Гэмт хэрэг үйлдсэн газар




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 14 буюу 0.4, аж ахуйн нэгж, байгууллагад 46 буюу 9.8, бусад газарт 423 буюу 15.6, төрийн байгууллагад 180 буюу 70.0 хувиар тус тус өсч, төрийн бус байгууллагад үйлдэгдсэн хэрэг 8 буюу 8.8, олон нийтийн газарт 80 буюу 9.8, гудамж талбайд 170 буюу 11.5, авто замд 159 буюу 19.5, нийтийн тээвэрт 15 буюу 36.6 хувиар тус тус буурсан байна.

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Орон нутагт 56.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 8.2 нэгжээр буурсан.

Улсын хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад 20.0 нэгжээр их байна.

### 2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 8944 хэрэг нээн шалгасан өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2417 хэрэг буюу 37.0 хувиар, үүнээс 5006 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1432 буюу 40.1 хувиар тус тус өсчээ.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 7511 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.5 хувиар буурсан. Холбогдогчдын 783 буюу 10.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 18.6 хувиар, 6728 буюу 89.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 10.6 хувиар, 461 буюу 6.1 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.2 хувиар тус тус буурсан байна.

### 3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 10246 хүн, 38 хуулийн этгээд хохирч, үүнээс 519 хүн нас барж, 3892 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 106 буюу 17.0 хувиар, гэмтсэн хүн 513 буюу 11.6 хувиар тус тус буурсан байна.

### 4.2. Учирсан хохирол

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 30957.4 сая төгрөгийн хохирлын 13364.3 сая төгрөг буюу 43.2 хувийг нөхөн төлүүлж, 10407.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



## Тав. Зөрчил

Орон нутгийн хэмжээнд нийт 444356 зөрчил шалгаж, 442104 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 77953 буюу 21.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 417759 буюу 94.0 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 8611 буюу 1.9 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 2473 буюу 0.6 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 15513 буюу 3.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 423916 иргэн, 73 хуулийн этгээдийг 20.033.6 сая төгрөгөөр торгох, 6919 хүнийг баривчлах, 11196 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулжээ.

Орон нутагт нийт 29758 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4438 буюу 13.0 хувиар буурсан байна.

---oooOooo---

# АРХАНГАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

### 1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Архангай аймаг дахь цагдаагийн газар 2018 он иргэн, хуулийн этгээдээс 1767 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 802 буюу 45.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 965 буюу 54.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

### 1.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 519 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 5 буюу 1.0 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.9 хувийг эзэлж байна.

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/**




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 468 гэмт хэрэг, сард 39 гэмт хэрэг, хоногт 1 гэмт хэрэг бүртгэгдсэн.

### 1.3. Бүртгэгдсэн гэмт хэрэг /сумдаар/



| № | Сум | 2017 | 2018 | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| 1 | Батцэнгэл сум | 15 | 17 | 2 | 13.3 |
| 2 | Булган сум | 11 | 21 | 10 | 90.9 |
| 3 | Жаргалант сум | 11 | 8 | -3 | -27.3 |
| 4 | Их тамир сум | 26 | 26 | 0 | 0.0 |
| 5 | Өгийнуур сум | 29 | 18 | -11 | -37.9 |
| 6 | Өлзийт сум | 18 | 19 | 1 | 5.6 |
| 7 | Өндөр улаан сум | 22 | 12 | -10 | -45.5 |
| 8 | Тариат сум | 16 | 19 | -3 | 18.8 |
| 9 | Төвшрүүлэх сум | 17 | 19 | 2 | 11.8 |
| 10 | Хайрхан сум | 16 | 21 | 5 | 31.3 |
| 11 | Хангай сум | 10 | 5 | -5 | -50.0 |
| 12 | Хашаат сум | 18 | 22 | 4 | 22.2 |
| 13 | Хотонт сум | 25 | 22 | -3 | -12.0 |
| 14 | Цахир сум | 7 | 4 | -3 | -42.9 |
| 15 | Цэнхэр сум | 29 | 47 | 18 | 62.1 |
| 16 | Цэцэрлэг сум | 21 | 9 | -12 | -57.1 |
| 17 | Чулуут сум | 38 | 6 | -32 | -84.2 |
| 18 | Эрдэнэбулган сум | 162 | 203 | 41 | 25.3 |
| 19 | Эрдэнэмандал сум | 23 | 21 | -2 | -8.7 |




### 1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 39.2 хувиар,
- хүнд гэмт хэрэг 34.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### 1.5. Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, орон нутгийн нийт гэмт хэрэгт эзлэх хувь[13]




[13] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

### 1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /*Эрүүгийн хуулийн бүлгээр*/

| № | Гэмт хэргийн төрөл | | Бүртгэгдсэн хэрэг | | Өсөлт, бууралтын хувь | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2017 он | 2018 он | | |
| 1 | Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг | | 4 | 5 | 25.0 | 1.0 |
| | Үүнээс: Хүнийг алах | | 1 | 4 | 4.0 дахин | 0.8 |
| 2 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | | 158 | 176 | 11.4 | 33.9 |
| | Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх | | 5 | 7 | 40.0 | 1.3 |
| 3 | Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | | 9 | 12 | 33.3 | 2.3 |
| | Үүнээс: Хүчиндэх | | 6 | 12 | 2.0 дахин | 2.3 |
| 4 | Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг | | 1 | 3 | 3.0 дахин | 0.5 |
| 5 | Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг | | 1 | - | - | - |
| 6 | Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг | | - | 1 | - | 0.2 |
| 7 | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | | 262 | 244 | -6.9 | 47.0 |
| | Үүнээс | Хулгайлах | 153 | 109 | -28.8 | 21.0 |
| | | Залилах | 14 | 26 | 85.7 | 5.0 |
| | | Дээрэмдэх | 3 | 3 | - | 0.6 |
| | | Мал хулгайлах | 74 | 91 | 23.0 | 17.5 |
| 8 | Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг | | 3 | 2 | -33.3 | 0.4 |
| 9 | Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | | 8 | 2 | -75.0 | 0.4 |
| 10 | Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг | | 2 | 1 | -50.0 | 0.2 |
| 11 | Авлигын эсрэг гэмт хэрэг | | 5 | 12 | 2.4 дахин | 2.3 |
| 12 | Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | | 2 | 5 | 2.5 дахин | 1.0 |
| 13 | Хүрээлэн байгаа орчны эсрэг | | 15 | 18 | 20.0 | 3.5 |
| 14 | Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг | | - | 1 | - | 0.2 |
| 15 | Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг | | - | 1 | - | 0.2 |
| 16 | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | | 44 | 36 | -18.2 | 6.9 |
| | Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих | | 40 | 34 | -15.0 | 6.6 |

### 1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 20 буюу 30.3, Лхагва гарагт 3 буюу 3.8, Баасан гарагт 8 буюу 11.4, Ням гарагт 7 буюу 13.0 хувиар тус тус өсч, Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 4 буюу 4.9, Пүрэв гарагт 16 буюу 17.8, Бямба гарагт 13 буюу 17.3 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06 -14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 21 буюу 28.4, 14-19 цагийн хооронд 5 буюу 3.9, 19-22 цагийн хооронд 16 буюу 24.2 хувиар өсч, 22-06 цагийн хооронд 37 буюу 15.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

### 1.8. Гэмт хэрэг үйлдсэн газар




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Төрийн байгууллагад үйлдэгдсэн хэрэг 1 буюу 6.3, бусад газарт 45 буюу 29.6 хувиар өсч, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 6 буюу 3.2, гудамж талбайд 5 буюу 8.3, авто замд 5 буюу 12.5, аж ахуйн нэгж, байгууллагад 4 буюу 23.5, олон нийтийн газарт 21 буюу 51.2 хувиар тус тус буурч, төрийн бус байгууллагад мөн үеийн түвшинд.

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Архангай аймагт 53.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс орон нутагт 7.1 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 2.9 нэгжээр бага байна.

### 2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 505 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 137 хэрэг буюу 37.2 хувиар, үүнээс 268 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 99 буюу 58.6 хувиар тус тус өссөн байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 327 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.6 хувиар буурсан.

Холбогдогчдын 21 буюу 6.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 22.2 хувиар, 306 буюу 93.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 5.3 хувиар, 11 буюу 3.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57.7 хувиар тус тус буурсан байна.

